



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/285

Арвайхээр

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Эрх шилжүүлэх тухай” 164 дүгээр тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.2.8 дугаарт батлагдсан Төрийн байгууллагуудын барилгын их засвар (Өвөрхангай, Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан сум)-д зарцуулах төсөл, арга хэмжээний 600,000,000 (зургаан зуун сая) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100631

Аймгийн Засаг даргын 2020 оны 07
дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар
захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦАД БАТЛАГДСАН IV.2.8 ХУУЛИЙН ДУГААРТАЙ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД ЭРХ ШИЛЖСЭН ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН БАРИЛГЫН ИХ ЗАСВАР (ӨВӨРХАНГАЙ, БАТ-ӨЛЗИЙ,
ХАРХОРИН, ХУЖИРТ, УЯНГА, ЗҮҮНБАЯН-УЛААН СУМ) ЗАРДЛЫН
ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төг/
1	Уянга сумын ЗДТГазрын барилгын их засвар	70,0
2	Зүүнбаян-Улаан сумын Эмгэд багийн төвийн их засвар	48,0
3	Уянга сумын Бадрал багийн төвийн их засвар	40,0
4	Хархорин сумын ЗДТГазрын 2-р байрны их засвар	60,0
5	Хужирт сумын ЗДТГазрын 2-р байрны их засвар	150,0
6	Хархорин сумын төрийн албан хаагчдын орон сууцны их засвар	60,0
7	Төрийн байгууллагуудын авто машины нэгдсэн гражын засвар	172,0
	НИЙТ ДҮН	600,0